



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 137

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор баглагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.3, 6.4 дэх хэсгийн 6.4.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Ахмадын хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 184,000.00 (нэг зуун наян дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ, 154,733.00 (нэг зуун тавин дөрвөн мянга долоон зуун гучин гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тавилга эд хогшлыг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө акталж устгах ажлын хүрээнд Ахмадын хорооны дарга Ц.Сугирт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Ахмадын хорооны өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2018 оны 2 сарын 28-ний өдрийн
 132 дугаар тогтоолын хавсралт

Ахмадын хорооныг үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ақталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглагч д өрсөн огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Ақлах гөрөл
1	Жижиг сандал	2012-12-17	ширхэг	4	11,000.00	44,000.00	26,400.00	17,600.00	Хөл нь хугарсан, тавцангийн панер салбарсан	1
2	Жижиг ширээ	2009-10-12	ширхэг	1	60,000.00	60,000.00	55,000.00	5,000.00		1
3	Сандал	2009-10-12	ширхэг	2	40,000.00	80,000.00	73,333.00	6,667.00	Хөл түшлэг хугарсан, наалт халаас авахгүй болсон	1
НИЙТ ДҮН										
						184,000.00 (нэг зуун наян дөрвөн мянга)	154,733.00 (нэг зуун тавин дөрвөн мянга долоон зуун гучин гурав)	29,267.00 (хорин есөн мянга хоёр зуун жаран долоо)		